

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	7
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	7
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	8
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3	Менежментийн захидал.....	8
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.4	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16
4.6	Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	18
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.02.28 № 06/354
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус төвийн дарга Ц. Батдорж Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Бодьтусгал Аудит ХХК-ийн аудитын баг санхүүгийн тайлангийн аудитыг хийлээ.

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын .25-наас 2019 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дуугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Бодьтусгал–Аудит ХХК–ийн аудитор Д. Долгорсүрэн, Р. Мядагмаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв нь 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2019 оны 01 дүгээр сарын 25-ны 01/19 дугаар бүхий албан бичгээр Бодьтусгал –Аудит ХХК –д ирүүлсэн.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв нь "Монгол улсад техник мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын үнэлгээ, баталгаажуулалтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, олон улсын жишигт нийцсэн үндэсний мэдээллийн сан бий болгосноор хөдөлмөрийн зах зээлд ажилтан, ажил олгогчийг холбоход оршино." гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн үйл ажиллагааны чиглэлийг

- Иргэний мэргэжлийн ур чадварыг үнэлж, мэргэжлийн түвшин тогтоох, салбарын хүний нөөц, үнэлгээний ажилтанг бэлтгэх, мэргэшүүлэх, давтан сургах, судалгаа шинжилгээ хийх, чадамжид суурилсан сургалтын үнэлгээний төлөвлөгөөг боловсруулж цахим мэдээллийн санг бүрдүүлэх гэж тодорхойлсон байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль
- Монгол улсын Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Засгийн газар болон холбогдох дээд шатны байгууллагаас гарсан тогтоол, шийдвэр, заавар, журмууд

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчны томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ төв санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 1 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1.0 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төсвийн нийт зарцуулалтыг хянахтай холбоотой юм.

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн 2018 оны нийт зардал 283,954.2 мянган төгрөг бөгөөд түүний 1.0 хувь болох 2,839.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1.0 хувиар тооцсон нь нийт зардлын хэмжээ, түүвэрлэлтээр илэрсэн эрсдэлтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлээ. гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Завсрын аудитын явцад зарим ажилчдын цалингийн сүлжээг буруу тогтоосноос 206.5 мянган төгрөг илүү олгосон байсныг 2018 оны 12 дугаар сарын цалингаас суутган тооцсон учир алдаанд аваагүй болно.

Гүйцэтгэлийн үе шатанд санхүүгийн үр дүнгийн тайлангийн уялдаа 4,203.7 мянган төгрөгийг үнэлгээний удирдлагын цогц системийн суурилуулалт бүрэн хийгдээгүй, бүртгэлд авагдаагүй байхад үр дүнгийн зардалд тусгасныг залруулан санхүүгийн байдлын тайлангийн урьдчилж гарсан зардалд тусгуулж, алдаа, зөрчилд тооцоогүй.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.
Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	0.00	
Дүн		1	0.00	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд орууллаа.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тус байгууллагын 2018 оны төсөвт өөрийн үйл ажиллагаанаас орлого олох төлөвлөгөө өгсөн боловч холбогдох дээд шатны байгууллагаас үйлчилгээний үнэ тарифыг тогтоож өгөөгүй учраас төлөвлөгөөгөө биелүүлэхийн тулд байгууллага дотооддоо хэлэлцэж, даргын тушаалаар үнэ тариф тогтоож мөрдсөн нь Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т *“Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага өөрийн үйл ажиллагаанаас орлого олох, зарцуулах, тайлагнах журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн болон санхүү төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.”* гэж заасныг зөрчсөн байна. Үйлчилгээний үнэ тариф тогтоолгох асуудлыг холбогдох дээд шатны байгууллагуудад удаа дараа тавьсан боловч шийдвэрлэж өгөөгүй байна.

Тус байгууллага үйл ажиллагаагаа явуулах өөрийн эзэмшлийн байргүй байсан. 2017 онд орон сууцны доод давхарын байрыг худалдан авсан байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас шинээр худалдан авсан байранд дахин үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзэж тодорхойлолт гарган өгсөн байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой улсын төсвөөс 111,132.6 мянган төгрөгийн санхүүжилт олгохоос санхүүжилтийг бүрэн авч зарцуулагдаагүй үлдэгдэл 12,709.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлжээ.

Өөрийн үйл ажиллагааны орлогоос 123,248.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 128,071.0 мянган төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 4,822.2 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Тайлант онд Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Мэргэжлийн боловсрол, сургалт” төслөөс хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 77,226.4 мянган төгрөгийн

санхүүжилт олгогдсон байна. Үүний 21,000.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 56,226.4 мянган төгрөгийг хөтөлбөрийн байгууллагад буцаан төвлөрүүлсэн байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 226,494.1 мянган төгрөг буюу 96,6 хувьтай байгаа бөгөөд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд 5,452.0 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 1,973.7 мянган төгрөгөөр, бусад зардлууд 380.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгджээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг шалгахад мэдээллийн санд 107 мэдээлэл оруулахаас 104 мэдээлэл оруулсан байна. Үүнээс 21 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 98.2 хувьтай байна.

Санхүүгийн программыг санхүүгийн ажилтнууд бүрэн ажиллуулж чадахгүй байгаатай холбоотой бөгөөд программаар тайлан гаргах асуудал удаашралтай байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Байгууллагын эрх зүйн орчинтой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллагын 2018 оны төсөвт өөрийн үйл ажиллагаанаас орлого олох төлөвлөгөө өгсөн боловч холбогдох дээд шатны байгууллагаас үйлчилгээний үнэ тарифыг тогтоож өгөөгүй учраас төлөвлөгөөгөө биелүүлэхийн тулд байгууллага дотооддоо хэлэлцэж, даргын тушаалаар үнэ тариф тогтоож мөрдсөн нь Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т *“Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага өөрийн үйл ажиллагаанаас орлого олох, зарцуулах, тайлагнах журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн болон санхүү төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.”* гэж заасныг зөрчсөн байна.

Эрсдэл

1. Байгууллагын үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө биелэхгүй байх
2. Байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдах

Зөвлөмж

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т *“Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага өөрийн үйл ажиллагаанаас орлого олох, зарцуулах, тайлагнах журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн болон санхүү төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.”* гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдлын тайлан
/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>6,985,788.00</u>	<u>88,130,400.78</u>
33	АВЛАГА	26,858.00	56,226,400.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	56,226,400.00
335	Бусад авлага	26,858.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	26,858.00	00.00
34	УРЬДЧИЛГАА	00.00	4,420,583.00
34600	Урьдчилж гарсан зардал	00.00	4,203,776.00
3471	Урьдчилгаа тооцоо	00.00	216,807.00
34713	Цалингийн урьдчилгаа	00.00	216,807.00
35	БАРАА МАТЕРИАЛ	6,958,930.00	27,483,417.78
354	Хангамжийн материал	6,958,930.00	27,483,417.78
35410	Бичиг хэргийн материал	5,830,800.00	20,901,108.00
35430	Сэлбэг хэрэгсэл	341,000.00	341,000.00
35440	Түлш, шатах тослох материал	286,000.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	501,130.00	6,241,309.78
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>949,520,695.48</u>	<u>1,342,727,521.88</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	949,520,695.48	1,342,727,521.88
392	Биет хөрөнгө	948,830,139.48	1,342,330,299.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	935,688,000.00	1,114,098,075.21
39202	Хуримтлагдсан элэгдэл	-12,995,666.70	-37,510,970.52
39203	Авто-тээврийн хэрэгсэл	38,633,000.00	38,633,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-20,389,638.88	-26,828,472.16
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	9,874,000.00	165,943,700.82
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1,979,554.94	-9,474,924.33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	00.00	98,782,769.66
39208	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-1,312,879.52
393	Биет бус хөрөнгө	690,556.00	397,222.72
39301	Програм хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-189,444.00	-482,777.28
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>956,506,483.48</u>	<u>1,430,857,922.66</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>8,500.80</u>	<u>165,099.43</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,500.80	165,099.43
413	Өглөг	8,500.80	165,099.43
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	8,500.80	165,099.43
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>956,497,982.68</u>	<u>1,430,692,823.23</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	956,497,982.68	1,430,692,823.23
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	8,944,100.00	8,944,100.00
51101	Өмч: - төрийн	8,944,100.00	8,944,100.00
512	Хуримтлагдсан үр дүн	947,553,882.68	1,421,748,723.23
51210	Өмнөх үеийн үр дүн	947,553,882.68	947,553,882.68
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	474,194,840.55

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>956,506,483.48</u>	<u>1,430,857,922.66</u>
---	--	------------------------------	--------------------------------

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,200,547,250.00	758,149,055.47
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,089,551,150.00	647,016,455.47
120	Нийтлэг татварын бус орлого	1,089,551,150.00	647,016,455.47
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,089,551,150.00	647,016,455.47
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	94,870,000.00	128,071,000.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	39,659,150.00	77,226,400.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	955,022,000.00	441,719,055.47
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	110,996,100.00	111,132,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	110,996,100.00	111,132,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	110,996,100.00	111,132,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	252,895,667.41	283,954,214.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	252,895,667.41	283,954,214.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	242,274,465.41	271,244,702.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	143,252,304.51	149,110,793.00
210101	Үндсэн цалин	143,252,304.51	149,110,793.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,938,816.49	18,244,328.75
210201	Тэтгэврийн даатгал	12,045,527.11	12,208,188.75
210202	Тэтгэмжийн даатгал	804,758.30	1,509,035.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	952,891.76	1,207,229.00
210204	Ажилгүйдлийн даатгал	195,295.56	301,806.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,940,343.76	3,018,070.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,361,815.00	4,275,886.88
210301	Гэрэл, цахилгаан	00.00	1,182,942.00
210302	Түлш, халаалт	2,263,415.00	2,659,906.00
210303	Цэвэр, бохир ус	98,400.00	433,038.88
2104	Хангамж, бараа материалын зардал	20,066,274.99	18,946,390.00
210401	Бичиг хэрэг	13,938,350.00	8,635,235.00
210402	Тээвэр, шатахуун	3,825,249.99	5,236,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	325,500.00	2,552,473.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	222,700.00	222,740.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,754,475.00	2,299,942.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	320,000.00	00.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	320,000.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	15,225,800.00	6,887,648.00
210702	Дотоод албан томилолт	15,225,800.00	6,887,648.00

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,755,350.00	14,317,143.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	473,100.00	473,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,500.00	60,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	460,000.00	307,648.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	9,761,750.00	11,475,895.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,354,104.42	59,462,513.17
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,956,788.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,842,000.00	17,450,005.88
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,512,104.42	40,055,719.29
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,621,202.00	12,709,512.12
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,900,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,900,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,721,202.00	12,709,512.12
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,721,202.00	12,709,512.12
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	947,651,582.59	474,194,840.55
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	947,651,582.59	474,194,840.55

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>245,525,250.00</u>	<u>316,430,000.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	134,529,150.00	205,297,400.00
120	Нийтлэг татварын бус орлого	134,529,150.00	205,297,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	134,529,150.00	205,297,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	94,870,000.00	128,071,000.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	39,659,150.00	77,226,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	110,996,100.00	111,132,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	110,996,100.00	111,132,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	110,996,100.00	111,132,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>245,525,250.00</u>	<u>314,838,000.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	245,525,250.00	314,838,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	234,904,048.00	245,902,087.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	143,350,123.00	149,327,600.00
210101	Үндсэн цалин	143,350,123.00	149,327,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,814,500.00	18,767,199.00
210201	Тэтгэврийн даатгал	15,814,500.00	18,767,199.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,361,815.00	4,275,886.88
210301	Гэрэл, цахилгаан	00.00	1,182,942.00
210302	Түлш, халаалт	2,263,415.00	2,659,906.00
210303	Цэвэр, бохир ус	98,400.00	433,038.88
2104	Хангамж, бараа материалын зардал	20,531,350.00	24,145,553.00
210401	Бичиг хэрэг	14,147,200.00	9,731,500.00
210402	Тээвэр, шатахуун	3,911,250.00	4,950,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	581,250.00	2,667,473.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	222,700.00	222,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,668,950.00	6,573,880.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,590,900.00	00.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,590,900.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	13,253,800.00	6,887,648.00
210702	Дотоод албан томилолт	13,253,800.00	6,887,648.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,153,460.00	22,957,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	473,100.00	473,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,500.00	60,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,619,860.00	1,915,200.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	15,000,000.00	18,509,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,848,100.00	19,540,401.00

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	2,093,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,848,100.00	17,447,401.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,621,202.00	68,935,912.12
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		
	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,721,202.00	68,935,912.12
213303		6,721,202.00	68,935,912.12
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	1,592,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	1,592,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	1,592,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	1,592,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	1,592,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-1,592,000.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
	2017 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	8,944,100.00	-831,728.31	8,112,371.69
	Тайлант үеийн үр дүн		948,385,610.99	948,385,610.99
C08	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	8,944,100.00	947,553,882.68	956,497,982.68
D01	2018 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	8,944,100.00	947,553,882.68	956,497,982.68
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,944,100.00	947,553,882.68	956,497,982.68
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	474,194,840.55	474,194,840.55
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,944,100.00	1,421,748,723.23	1,430,692,823.23

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	234,381,400.00	226,494,087.88	7,887,312.12	96.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	234,381,400.00	226,494,087.88	7,887,312.12	96.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	234,381,400.00	226,494,087.88	7,887,312.12	96.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	149,425,800.00	149,327,600.00	98,200	99.9
210101	Үндсэн цалин	111,676,700.00	149,327,600.00	-37,650,900	133.7
210102	Нэмэгдэл	27,245,200.00	00.00	27,245,200	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,503,900.00	00.00	10,503,900	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,931,100.00	17,931,100.00	0	
210201	Тэтгэврийн даатгал	11,954,100.00	17,931,100.00	5,977,000.00	150.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,494,200.00	00.00	1,494,200.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,195,400.00	00.00	1,195,400.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	298,900.00	00.00	298,900.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	2,988,500.00	00.00	2,988,500.00	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,727,900.00	4,275,886.88	5,452,013.12	44.0
210301	Гэрэл, цахилгаан	2,449,500.00	1,182,942.00	1,266,558.00	48.3
210302	Түлш, халаалт	5,920,000.00	2,659,906.00	3,260,094.00	44.9
210303	Цэвэр, бохир ус	1,358,400.00	433,038.88	925,361.12	31.9
2104	Хангамж, бараа материалын зардал	25,577,800.00	23,604,053.00	1,973,747.00	92.3
210401	Бичиг хэрэг	9,190,000.00	9,190,000.00	9,190,000.00	100
210402	Тээвэр, шатахуун	4,950,000.00	4,950,000.00	4,950,000.00	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,564,000.00	2,667,473.00	896,527.00	74.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	222,700.00	222,700.00	1,077,220.00	85.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,651,100.00	6,573,880.00	58,000.00	96.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,650,000.00	1,592,000.00	58,000.00	96.5
210601	Багаж, техник,	1,650,000.00	1,592,000.00	58,000.00	96.5

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	хэрэгсэл				
2107	Томилолт, зочны зардал	3,838,000.00	3,722,648.00	115,313.00	97.0
210702	Дотоод албан томилолт	3,838,000.00	3,722,648.00	115,313.00	97.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,147,800.00	22,957,800.00	190,000.00	99.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00		
210803	Даатгалын үйлчилгээ	594,000.00	473,100.00	120,900.00	79.6
210804	Тээврийн хэрэгслийн татвар	118,800.00	60,500.00	58,300.00	50.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,926,000.00	1,915,200.00	10,800.00	99.4
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	18,509,000.00	18,509,000.00		100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3083000.00	3083000.00		100
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,093,000.00	2,093,000.00		100
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	990,000.00	990,000.00		100
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	234,381,400.00	226,494,087.88	7,887,312.12	96.6
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	111,132,600.00	98,423,087.88	12,709,512.12	88.6
131001	Улсын төсвөөс санхүүжих	111,132,600.00	98,423,087.88	12,709,512.12	88.6
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	123,248,800.00	128,071,000.00	4,822,200.00	103.9
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	123,248,800.00	128,071,000.00	4,822,200.00	103.9
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	13	16	-3	
620001	Удирдах ажилтан	1	1		
620002	Гүйцэтгэх ажилтан	12	12		
620003	Үйлчлэх ажилтан	0	3	-3	

4.6 НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	77,226,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	21,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,000,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	836,099.00
210201	Тэтгэврийн даатгал	836,099.00
2104	Хангамж, бараа материалын зардал	541,500.00
210401	Бичиг хэрэг	541,500.00
2107	Томилолт, зочны зардал	3,165,000.00
210702	Дотоод албан томилолт	3,165,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,457,401.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,457,401.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,226,400.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	56,226,400.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	56,226,400.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	77,226,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	77,226,400.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	77,226,400.00

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Аудитын код:
2019/2/25	Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудит	САГ-2019/58/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төв	Мянган төгрөгөөр

№	Аудитын зорилт, чиглэл	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	1	3	4	9	10
1	Тухайн байгууллага салбартай холбоотой хууль эрх зүйн орчин	Холбогдох дээд байгууллагын шийдвэргүйгээр үйлчилгээний үнэ тариф тогтоож мөрдсөн	0	Дарга Нягтлан бодогч	Ц.Батдорж Л.Ганчулуун

